



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 06 сарын 04 өдөр

Дугаар A/133

Улаанбаатар хот

Журам боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаанд “Чанарын менежментийн тогтолцооны стандарт MNS ISO 9001:2015”-ыг нэвтрүүлэхтэй холбогдуулан стандартын шаардлагын дагуу Баримт бичиг боловсруулах, баримт бичгийн хяналтын журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр, Баримт бичгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтын журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2 дугаар, Яамны дотоод аудит хийх журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 3 дугаар, Үл тохирлын хяналтын журам, үл тохирлыг залруулах үйл ажиллагааны журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 4 дүгээр, Удирдлагын дүн шинжилгээ хийх журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалын нэг дэх заалтад заасан журмуудын төслийг боловсруулж, 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор удирдлагад танилцуулан батлуулахыг Ажлын хэсэг /Б.Гүнболд, Д.Баярсайхан, Л.Идэрцогт, Н.Нарантуяа, Б.Нямдорж/-т даалгасугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/133 дугаар тушаалаар томилогдсон яамны Чанарын менежментийн баг /Б.Гүнболд/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Л.Идэрцогт/-т тус тус даалгасугай.


ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

152220503

Барилга, хот байгуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2024 оны...06... дугаар сарын
...04 ны өдрийн АН/29 дугаар
тушаалын 1... дугаар хавсралт



**БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ
БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ахлагч

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан

Гишүүд:

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Ц.Батчимэг;

Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч М.Ням-Очир.

Нарийн бичгийн дарга:

Төрийн захиргааны удирдлагын газрын бичиг хэргийн эрхлэгч
Б.Мөнхтуул, архивч-операторч Ю.Нямсүрэн.

-----***-----

Барилга, хот байгуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2024 оны 06 дугаар сарын
07 ны өдрийн 4199 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт



**БАРИМТ БИЧГИЙН БҮРТГЭЛ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ЖУРАМ
БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ахлагч

Төрийн захиргааны удирдлагын газрын Статистик, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Нарантуяа

Гишүүд:

Төрийн захиргааны удирдлагын газрын шинжээч Д.Гэрэлмаа;


Статистик, мэдээллийн технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Баасан.

Нарийн бичгийн дарга:

Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч Б.Цолмон.

-----***-----

Барилга, хот байгуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2024 оны...06... дугаар сарын
...07... ны өдрийн... дугаар
тушаалын... дугаар хавсралт



ЯАМНЫ ДОТООД АУДИТ ХИЙХ ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Идэрцогт

Гишүүд:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын ахлах
шинжээч А.Гэрэлт-Од;


Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтсийн
мэргэжилтэн Б.Биндэрьяа.

Нарийн бичгийн дарга:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын шинжээч
Ц.Ууганбаяр.

-----***-----

Барилга, хот байгуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2021 оны.....06.....дугаар сарын
.....04.....ны өдрийн... А/44 дугаар
тушаалын .4.. дугаар хавсралт



ҮЛ ТОХИРЛЫН ГАРАЛТ, ХЯНАЛТЫН ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ
ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга
Б.Нямдорж

Гишүүд:

Барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах шинжээч
А.Энхтүвшин;

Статистик, мэдээллийн технологийн хэлтсийн шинжээч
Э.Ариунцэцэг.

Нарийн бичгийн дарга

Хуулийн хэлтсийн шинжээч Б.Мягмардорж.

-----***-----

Барилга, хот байгуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын
2024 оны 06 дугаар сарын
04 ны өдрийн 469 дугаар
тушаалын 5 дугаар хавсралт

УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ БОЛОВСРУУЛАХ
ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Гүнболд

Гишүүд:

Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын ахлах шинжээч Д.Бэлэгсайхан;

Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч
А.Лхамсэржид.

Нарийн бичгийн дарга

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газрын шинжээч
Ц.Ууганбаяр.

-----***-----